



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 04

Улаанбаатар 2021

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан  
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Жил бүрийн хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч улс ах орон, нийгэм эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулсаар байна. Улсын хэмжээнд 2020 онд Улаанбаатар хот, Архангай, Булган, Говьсүмбэр, Завхан, Дорнод, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Төв, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Увс зэрэг 15 аймгийн 74 суманд нийт 142 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч, 245.311 га талбай өртөж, экологийн хохирол 3 тэрбум, эд материал 41.1 сая, түймрийг унтраахад 145.4 сая төгрөг зарцуулж, нийт 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Оросын Холбооны Улсаас нийт 4 удаагийн хээрийн гал түймэр Монгол Улсын хилийг даван орж ирж, 3933 га хээрийн талбай гал түймэрт өртсөн. Монгол Улсаас БНХАУ-ын хилийг давж 1 удаа, ОХУ-ын хилийг давж 1 удаа, нийт 2 удаагийн хээрийн гал түймэр хилийг давж гарсан байна.

Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр 2021 оны 3, 4 дүгээр сард агаарын температур Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Дорнод Монголын тал нутгаар олон жилийн дунджаас 1-1.5 градусаар илүү дулаан, 3, 4 дүгээр саруудад олон жилийн дунджаас бага хур тунадастай, нийт нутгаар хуурайшилтын зэрэг өндөр байх мэдээлэл ирүүлсэн.

Иймд 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2.2, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент, Covid-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий шаардлага, MNS ISO/PAS 45005:2021 стандарт, мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг сайжруулах, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Уртнасанд

1.1. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодод Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 108 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан техник багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, балтгал, бэлэн байдлыг дээшлүүлэн ажиллахыг.

1.2. Ойн тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 13 дугаар зүйлийн 13.1.16-д заасны дагуу цаг уур, орчны шинжилгээний газраас сансрын хиймэл дагуулын мэдээллээр авсан цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг /баяр, амралтын өдрүүдэд/ шуурхай боловсруулж, Онцгой байдлын байгууллагад хүргүүлэхийг.

1.3. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.30-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн аюултай үед ой, хээрийн гал түймрээс сэргэмжлүүлэх, орон нутагт эргүүл, харуул ажиллуулах болон энэ ажилд бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахыг.

1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.4-т заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бүс нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын нислэг үйлдэх зардлыг төсөвт тусгаж, Зэвсэгт хүчний байгууллагатай хамтран нислэг үйлдэхийг.

1.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2.15-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюул тулгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийтийг мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах, нэвтрүүлэг бэлтгэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах.

1.6. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай үед ашиглахыг.

1.7. Ойн тухай хуулийн дагуу хавар, намрын хуурайшилтын улиралд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, хууль, дүрэм, журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэхийг.

1.8. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр нэмж хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулахыг.

Хойр, Аймаг, нийслэлийн Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт

2.1. Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг Онцгой байдлын байгууллагад тухай бүр болон хагас, бүтэн жилээр гаргаж өгөхийг.

2.2. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулахыг.

2.3. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс учирсан хохирлыг хуулийн хугацаанд тогтоож, тайланд тусгахыг.

2.4. Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлтийн 1.7.1-д заасныг хэрэгжүүлэн хавар, намрын хуурайшилтын улиралд Засаг даргын захирамжаар хуваарь гарган хөдөлгөөнт эргүүл, шалгалт хийх, шаардлагатай газар нутагт хяналтын цэг байгуулан ажиллуулахыг.

2.5. Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хэвсрэлтэд заасны дагуу оум, дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулахыг.

2.6. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гэмшгээс хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн ой, хээрийн гал түймэр унтраах сургалт, дадлагыг зохион байгуулахыг.

2.7. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний орон нутгийн хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавихыг.

2.8. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг, нийслэлээс нэмэлт хүн хүч дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор харьяа эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагаас тусгай баг томилон ажиллуулахыг.

2.9. Бүх шатны Засаг дарга нар 03 дугаар сарын 20-оос 06 дугаар сарын 10, 06 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гарган хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг.

Гурав, Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч,  
Бригадын генерал Г.Сайханбаярт

3.1. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх нисэх онгоц, нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник харагсал хүрэлцэн очих боломжгүй аялагдажсан ой,

1.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2.15-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюул тулгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийтийг мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах, нэвтрүүлэг бэлтгэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах.

1.6. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай үед ашиглахыг.

1.7. Ойн тухай хуулийн дагуу хавар, намрын хуурайшилтын улиралд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, хууль, дүрэм, журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэхийг.

1.8. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр нэмж хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулахыг.

Хойр, Аймаг, нийслэлийн Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт

2.1. Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг Онцгой байдлын байгууллагад тухай бүр болон хагас, бүтэн жилээр гаргаж өгөхийг.

2.2. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулахыг.

2.3. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс учирсан хохирлыг хуулийн хугацаанд тогтоож, тайланд тусгахыг.

2.4. Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлтийн 1.7.1-д заасныг хэрэгжүүлэн хавар, намрын хуурайшилтын улиралд Засаг даргын захирамжаар хуваарь гарган хөдөлгөөнт эргүүл, шалгалт хийх, шаардлагатай газар нутагт хяналтын цэг байгуулан ажиллуулахыг.

2.5. Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хэвсрэлтэд заасны дагуу оум, дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулахыг.

2.6. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын тархалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гэмшгээс хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн ой, хээрийн гал түймэр унтраах сургалт, дадлагыг зохион байгуулахыг.

2.7. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний орон нутгийн хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавихыг.

2.8. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг, нийслэлээс нэмэлт хүн хүч дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор харьяа эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагаас тусгай баг томилон ажиллуулахыг.

2.9. Бүх шатны Засаг дарга нар 03 дугаар сарын 20-оос 06 дугаар сарын 10, 06 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гарган хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг.

Гурав, Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч,  
Бригадын генерал Г.Сайханбаярт

3.1. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх нисэх онгоц, нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник харагсал хүрэлцэн очих боломжгүй аялагдажсан ой,



Зургаа. Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн,  
Цагдаагийн хурагдав Ж.Болдод

6.1. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, энэ тухай холбогдох мэдээллийг улирал бүр Улсын онцгой комисст ирүүлэхийг.

6.2. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн аюултай үед ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох, орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран бэйнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэг ажиллуулахыг.

6.3. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/10 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэн ажиллахыг.

6.4. Ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад мэдэгдэх, харилцан шуурхай солилцохыг.

Долоо. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, Т.Гантулгад

7.1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэхийг.

7.2. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцохыг.

7.3. Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцохыг.

Энэхүү албан даалгаарын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайлан Улсын онцгой комиссын ажлын албанд 6 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус тус ирүүлэхийг холбогдох комиссын гишүүд, дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН